

“МОНГОЛ-21” САНГИЙН ТУХАЙ

Тус сан нь анх Монгол улсын хөдөлмөрийн баатар, техникийн шинжлэх ухааны доктор Шагдарын Отгонбилэгийн санаачлагаар 1997 оны 8 дугаар сарын 29-д байгуулагдан 14 дэхь жилдээ үйл ажиллагаагаа явуулж байна. Тус сан үүсэн байгуулагдсан цагаасаа эхлэн уул уурхайн мэргэжилтэй үндэсний боловсон хүчин бэлтгэх, өсвөр үеийн хүүхэд залуучуудыг урлаг, спортын өв тэгш хүмүүжилтэй болгох, дэлхийд монголын тамирчдын нэр алдрыг бадруулах, хөдөөгийн ард олны аж амьдралыг дээшлүүлэх, тэдний аятай тухтай, тогтвор суурьшилтай амьдрах материаллаг орчин бүрдүүлэх, хөдөөгийн малчид хөдөлмөрчдийн эрүүл мэндийг хамгаалах, нийгмийн асуудлыг оновчтой шийдвэрлэхэд онцгой анхаарч ирлээ.

Эрдэнэтчүүдийн санал, санаачлага, манай сангийн хамтын ажиллагааны үр дүнд Эрдэнэт үйдвэрийн дэргэдэх Технологийн их сургуулийг 2001 оны 6 сард Монгол улсын засгийн газрын шийдвэрээр Ш.Отгонбилэгийн нэрэмжит болгов. Жил бүр уг технологийн сургуулийн шилдэг хоёр сурагч, нэг багшид мөнгөн тэтгэлэг, урамшуулал олгон ирлээ.